



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А30

Хужирт сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А1248 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч тархсан 1, 2, 3, 4, 5, 6 дугаар багийн нийт 3667 га бэлчээрт микробиологийн аргаар тэмцэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 05-10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.
2. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, хяналт тавих, үр дүнг тооцох ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.
3. Мэрэгчтэй тэмцэх ажилд малчид, малчны бүлэг, хоршооны гишүүдийг хамруулах, тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх, богино хугацаанд бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Б.Дэмбэрэлд үүрэг болгосугай.
4. Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч Б.Бямбасүрэн, ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг заавар журмын дагуу гаргаж 2024 оны 05 дугаар сарын 01-ний дотор Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Д.Мөнхбат нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАТБАЯР

622401059

D:Alban bichig;Zahiramj 2024